



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 19 өдөр

Дугаар А/12 .

Хэрлэн сум

Тусгай зөвшөөрөл сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 16 дугаар зүйлийн 16.2, 16.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын 2017 оны 12 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Бор-Өндөр сумын “Азын нахиа”, “Монавит” эмийн сан, Хэрлэн сум “Онош” лаборатори, Баянмөнх сумын “Агаарын тунгалаг” уламжлалтын үүдэн эмнэлэг, “Монос Фарма Трейд” эм ханган нийлүүлэх ХХК-ний тусгай зөвшөөрлийн хугацааг тус тус сунгасугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгагдсан эрүүл мэндийн байгууллагуудын тусгай зөвшөөрлийн хугацааг хавсралтаар баталсугай.

3. Дээрх байгууллагуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Гэрэлмаа/-д үүрэг болгосугай.


4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох комиссын дарга бөгөөд аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА



Аймгийн Засаг даргын 2018 оны  
... дугаар сарын ... өдрийн ...  
дугаар захирамжийн хавсралт



**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ СУНГАСАН ЭМНЭЛЭГ, ЭМИЙН САН** СЮА0005 9076603

д/д	Байгууллага нэр	Эрхлэгч	Байрлал	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа	
1	"Азын нахиа"	Б.Сэмпэн	Бор-Өндөр сум	Эмийн сан	1 жил	2017.10.22 2018.10.22
2	"Монавит"	Ч.Чулуунсүрэн	Бор-Өндөр сум	Эмийн сан	1 жил	2017.10.22 2018.10.22
3	"Онош"	Р.Уранчимэг	Хэрлэн сум IV баг	Лаборатори	1 жил	2018.01.03 2019.01.03
4	"Агаарын тунгалаг"	Э.Баатарчулуун	Баянмөнх сум	Уламжлалтын үүдэн эмнэлэг	1 жил	2017.09.25 2018.09.25
5	"Монос Фарма Трейд" эм ханган нийлүүлэх	Ч.Түмэнжаргал	Хэрлэн сум	Эм ханган нийлүүлэх	1 жил	2017.10.22 2018.10.22